

ТЕМПЕРАМЕНТЭД СУУРИЛСАН СУРГАЛТЫН АРГА БАРИЛЫГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТАД ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖ

Aorigele¹, Нарангэрэл Зулцэцэг^{2}, Зундуй Ариунаа²*

¹Үндэстний Их Сургуулийн Хараат Эмнэлгийн Хороо,

Өвөр Монголын Өөртөө Засах Орон, БНХАУ

²Сургалтын Бодлого, Зохицуулалтын Алба, Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль,

Улаанбаатар, Монгол Улс

**цахим хаяг: zultsetseg@monos.mn*

THE POTENTIAL FOR IMPLEMENTING TEMPERAMENT-BASED INSTRUCTIONAL METHODS IN HIGHER EDUCATION

Aorigele¹, Zultsetseg Narangerel^{2}, Ariunaa Zundui²*

¹Affiliated Hospital of Inner Mongolia University for the Nationalities,

Inner Mongolia Autonomous Region, China

²Office of Academic Policy and Coordination, Mongolian University of Pharmaceutical Sciences,

Ulaanbaatar, Mongolia

** email: zultsetseg@monos.mn*

Abstract: Temperament is an innate psychological characteristic that influences emotional responses, behavioral patterns, learning styles, and academic performance. In educational settings, understanding students' temperament has become increasingly important for improving learning outcomes, engagement, and instructional effectiveness. This review aims to synthesize theoretical and empirical evidence on the relationship between student temperament and learning outcomes, and to identify teaching methods and instructional strategies that are aligned with different temperament types.

In reviewed studies, a variety of methods have commonly been used to assess students' learning styles, temperament, and psychological attitudes, including questionnaires, learning ability tests, standardized psychological tests, and teacher evaluations. Statistical techniques such as correlation, regression, and cluster analysis are often employed to analyze data and provide a comprehensive evaluation of learning outcomes.

Previous studies consistently demonstrate that temperament significantly influences learning behavior, attention, stress responses, and academic achievement. Sanguine and choleric students benefit more from interactive and competitive learning environments, whereas phlegmatic and melancholic students achieve better outcomes in stable, structured, and supportive settings. Empirical evidence further suggests that aligning teaching strategies with students' temperament characteristics enhances learning effectiveness and student engagement.

Temperament is a critical individual factor affecting learning outcomes and academic success. Rather than attempting to change temperament, educational strategies should focus on recognizing and supporting individual differences. Integrating temperament-sensitive teaching approaches into curriculum design can substantially improve educational quality and learning outcomes.

Үндэслэл

Сүүлийн жилүүдэд дээд боловсролын сургалтын чанарыг дээшлүүлэх, суралцагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх асуудал боловсролын судалгааны анхаарлын төвд байсаар байна. Энэхүү зорилгод хүрэхийн тулд суралцагчийн хувь хүний онцлог, тэр

дундаа сэтгэл зүйн хүчин зүйлсийг сургалтын үйл явцад системтэйгээр харгалзан үзэх шаардлага улам бүр нэмэгдэж байна. Оюутны темперамент нь суралцах хандлага, идэвх, мэдээлэл боловсруулах хэв маягт шууд нөлөөлдөг суурь сэтгэл зүйн хүчин зүйлсийн нэг юм.

Олон улсын судалгаанд темпераментэд суурилсан сургалтын хэлбэр, арга барил нь суралцах идэвх, урам зориг, сургалтын амжилтад эерэг нөлөө үзүүлдэг болохыг тогтоосон байдаг. Гэвч эдгээр судалгааны ихэнх нь гадаадын боловсролын орчинд хийгдсэн бөгөөд Монголын дээд боловсролын салбарт уг хандлагыг эмпирик түвшинд судалж, бодит сургалтын орчинд хэрэгжүүлэх боломжийг тодорхойлсон судалгаа харьцангуй хомс байна. Энэ нь судалгааны бодит хэрэгцээ байгааг илтгэж байна.

Энэхүү судалгаа нь оюутны темперамент, сургалтын арга барил, суралцах идэвх, сургалтын амжилтын хоорондын харилцан хамаарлыг цогцоор нь авч үздгээрээ өмнөх дотоодын судалгаануудаас ялгаатай бөгөөд Монголын боловсролын сургалтын орчинд анхны эмпирик нотолгоонд суурилсан загвар боловсруулах боломжийг нээж байна. Иймд уг судалгаа нь дотоодын боловсрол судлалын онолын санг баяжуулахын зэрэгцээ дээд боловсролын сургалтын практикт шууд хэрэгжих арга зүйн суурь болох ач холбогдолтой.

Түүнчлэн энэхүү судалгаа нь оюутны темпераментийн онцлогт тохирсон сургалтын хэлбэр, арга барилын үр нөлөөг Монголын дээд боловсролын сургалтын орчинд эмпирик аргаар тодорхойлж, сургалтын практикт хэрэгжүүлэх боломжсанал, арга зүйн чиглэлийг боловсруулахад чиглэж байна. Судалгааны үр дүн нь боловсрол судлалын онолын хөгжилд хувь нэмэр оруулахын зэрэгцээ дээд боловсролын сургалтын практикт ашиглах боломжтой, шинжлэх ухааны үндэслэлтэй арга зүйн зөвлөмж боловсруулахад бодит ач холбогдолтой юм.

Оюутны темпераментэд тохирсон сургалтын хэлбэр, арга барилын онолын үзэл баримтлал: МЭӨ VII зуунд эртний Грекийн

эмч Гиппократ темпераментийг тодорхойлох анхны онолыг боловсруулжээ¹. Түүний номлосноор темперамент нь сангвиник, холерик, флегматик, меланхолик гэсэн дөрвөн үндсэн төрөлд хуваагддаг. Энэхүү ангиллыг үргэлжлүүлэн И.Павлов (1951), Г.Айзенк (1967) зэрэг эрдэмтэд темпераментийн талаарх онолын тодорхойлолтуудыг дэвшүүлж, тэдгээрийг физиологийн механизм болон зан төлөвийн онцлогтой уялдуулан шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөгжүүлсэн.²

Темпераментэд суурилсан сургалтын арга барилын онол, судлагдсан байдал:

Темперамент нь хувь хүний сэтгэл зүйн төрөлхийн, харьцангуй тогтвортой шинж чанар бөгөөд зан үйлийн эрчим, хэмнэл, сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл, идэвхжлийн түвшинг тодорхойлдог. Павлов темпераментийг мэдрэлийн үйл ажиллагааны хүч, тэнцвэр, хөдөлгөөнт чанараар тайлбарласан бол Айзенк экстраверси–интроверси болон нейротизм гэсэн хоёр үндсэн хэмжээсээр тодорхойлсон нь боловсролын судалгаанд өргөн хэрэглэгддэг. Эдгээр онол нь суралцагчийн хувь хүний ялгаатай байдлыг сургалтын арга зүйтэй уялдуулах онолын үндэс болдог.

Орчин үеийн боловсролын онолд сургалтын хэлбэр, арга барил нь суралцагчийн танин мэдэхүйн онцлог, сэтгэл зүйн хэрэгцээ, суралцах хэв маягт нийцсэн байх шаардлагатайг онцолдог. Үүний хүрээнд суралцагч төвтэй сургалт, ялгаатай сургалт, хувь хүнд тохирсон сургалт зэрэг хандлагууд давамгайлж байна. Суралцагч төвтэй сургалт нь оюутныг идэвхтэй оролцогч болгон, түүний хэрэгцээ, сонирхолд тулгуурлах бол ялгаатай сургалт нь суралцагчдын чадвар, онцлогт нийцүүлэн агуулга, арга, үнэлгээг зохицуулахад чиглэдэг. Харин хувь хүнд тохирсон сургалт нь суралцагч бүрийн сурах

замналыг оновчтой төлөвлөхөд анхаардаг.

Выготский “Нийгэм-соёлын онолд суралцах үйл явц нь нийгмийн харилцаа, хамтын ажиллагаанд суурилдаг” гэж үзсэн нь темпераментийн ялгаатай байдалд нийцсэн сургалтыг хэрэгжүүлэх онолын суурь болдог. Мөн Kolb-ийн туршлагад суурилсан суралцахуйн онол нь суралцагчид мэдээллийг хүлээн авах, боловсруулах хэв маягаараа ялгаатайг нотолж, темперамент ба суралцах хэв маягийн уялдааг судлахад чухал ач холбогдолтой.

Темпераментэд тохирсон сургалт гэдэг нь суралцагчийн төрөлхийн сэтгэл зүйн онцлогт нийцүүлэн сургалтын агуулга, арга зүй, зохион байгуулалтын хэлбэр, багш-оюутны харилцааг оновчтой төлөвлөхийг хэлнэ. Судалгаанд сангвиник оюутанд интерактив, хамтын ажиллагаанд суурилсан арга; холерик оюутанд зорилготой, өрсөлдөөнт, богино хугацааны идэвхтэй даалгавар; флегматик оюутанд тогтвортой, системтэй, бие даасан сургалт; меланхолик оюутанд тайван орчин, гүнзгий анализ, бичгийн ажилд суурилсан арга илүү тохиромжтой болохыг тогтоосон байна. Эдгээр арга барил нь суралцах идэвх, урам зориг, сургалтын үр дүнд эерэг нөлөө үзүүлдэг.

Темпераменттэй холбоотой боловсролын судалгаанууд 1980-аад оноос эрчимжиж, суралцахуйн амжилтад нөлөөлөх сэтгэл зүйн хүчин зүйлсийг нарийвчлан судалж эхэлсэн.^{3,4} Keogh, Lerner, Martin зэрэг судлаачид темперамент ба сурлагын амжилт, академик чадварын хоорондын хамаарлыг тогтоосон⁵ бол Zhang, Keirseу нар экстраверт оюутнууд хамтын сургалтад, интроверт оюутнууд бие даан, рефлексив аргаар илүү үр дүнтэй суралцдаг болохыг нотолсон.⁶ Brock & Hundley, Tomlinson нар темпераментэд суурилсан ялгаатай сургалт нь суралцах идэвх, урам зориг, сургалтын амжилтад эерэг нөлөөтэйг

онцолсон.⁸

Олон улсад темперамент, суралцах хэв маяг, ялгаатай сургалтыг онолын хувьд уялдуулан судалж, боловсролын практикт өргөн нэвтрүүлж байгаа бол Монгол Улсад энэ чиглэлийн судалгаа харьцангуй хомс хэвээр байна.⁷ Дотоодын судалгаанууд оюутны зан төлөв, суралцах идэвх, багшийн заах арга барилын уялдааг авч үзсэн боловч темпераментэд тусгайлан тохируулсан сургалтын арга зүйн үр нөлөөг эмпирик түвшинд судалсан ажил цөөн байна.

Иймд Монголын дээд боловсролын орчинд оюутны темпераментэд суурилсан сургалтын арга барилын үр нөлөөг нарийвчлан судалж, практикт хэрэгжүүлэх боломжтой онол-арга зүйн загвар боловсруулах нь шинжлэх ухааны болон практикийн чухал ач холбогдолтой. Энэхүү чиглэлийн судалгаа нь багш, сургалтын хөтөлбөр боловсруулагчдад суралцагчийн хувь хүний ялгааг харгалзан үзсэн сургалтыг төлөвлөх онолын суурь өгч, суралцах идэвх, сургалтын амжилтыг дээшлүүлэх боломжийг бүрдүүлэх юм.

Энэхүү тойм судалгаа нь оюутны темпераментийн төрөл болон суралцах идэвхийн онцлогт нийцсэн сургалтын арга барилын талаар хийгдсэн гадаад, дотоодын судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж, тэдгээрийн сургалтын амжилтад үзүүлэх нөлөө болон Монголын дээд боловсролын нөхцөлд хэрэгжүүлэх боломжийг тодорхойлох үндэслэл бий болгох зорилготой.

Дүн шинжилгээ, таамаглал

Орчин үеийн боловсролын судалгаанд суралцагчийн ялгаатай байдлыг харгалзан үзэх асуудал чухалчлагдаж байна. Суралцагчдын темперамент нь тэдний суралцах хэв маяг, идэвх оролцоо, хандлагад нөлөөлдөг суурь хүчин зүйлүүдийн нэг юм.

Иймд темпераментэд суурилсан сургалтын арга барилын онол, судалгааны үр дүнг нэгтгэн судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Энэхүү тойм судалгаанд суралцагчдын темпераментийн онцлогт суурилсан сургалтын арга барилын талаарх дотоодын болон олон улсын судалгаануудыг нэгтгэн дүн шинжилгээ хийлээ.

Олон улсад хийгдсэн сүүлийн үеийн судалгааны үр дүнгээс харахад дээд боловсролын сургалтын үйл явцад темпераментэд суурилсан сургалтын арга барилыг ашиглах нь оюутны суралцах идэвх, сэтгэл ханамж, хамтын ажиллагааны чадамжийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлж буйг тогтоосон үр дүнгүүд олон байна.

Оюутны темперамент ба суралцахуйн үр дүнгийн уялдааг судалсан судалгаануудуудаас тоймлоход темпераментийн хэлбэрүүд нь суралцахуйн үр дүнд бодитой нөлөө үзүүлдэг болохыг харуулж байна. Тухайлбал:

- Сангвиник, холерик төрлийн оюутнуудад интерактив, өрсөлдөөнт сургалтын арга илүү үр дүнтэй;
- Флегматик, меланхолик төрлийн оюутнуудад тогтвортой, тайван орчин, урт хугацааны даалгаварт суурилсан сургалтын арга илүү тохиромжтой байна.

Темпераментийн ялгааг харгалзан боловсруулсан сургалтын загваруудаас харахад багш-оюутны хоорондын харилцааг уян хатан болгож, сургалтын чанарыг дээшлүүлэхэд эерэг нөлөө үзүүлдэг байдал ажиглагдлаа.

Тодруулбал:

- Темпераментэд суурилсан хандлага нь суралцах үйл явцыг хувь хүний онцлогт нийцүүлж, оюутнуудын харилцаанд илүү идэвхтэй, нээлттэй оролцоог дэмждэг;
- Дотоод эргэцүүлэлд илүү төвлөрдөг

оюутнуудад бие даасан судалгаа, эссэ бичих арга барил илүү үр дүнтэй;

- Суралцах идэвх, ойлголтыг нэмэгдүүлэхэд темпераментэд тохирсон сургалтын арга нь оюутнуудыг илүү идэвхтэй оролцуулах, асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг;
- Багш нь оюутнуудын темпераментийн олон янз байдлыг харгалзан уян хатан, холимог арга хэрэглэснээр сургалтын үр дүн сайжирдаг;
- Темпераментэд суурилсан сургалтын арга барил нь ангийн уур амьсгалыг сайжруулж, багийн ажлын үр бүтээмжийг нэмэгдүүлдэг.

Дээрх үр дүнгээс харахад темперамент нь хувь хүний сэтгэл хөдлөл, үйл ажиллагааны хурд, эрч хүч, тогтвортой байдлыг илэрхийлдэг төрөлхийн сэтгэл зүйн онцлог бөгөөд суралцах хэв маяг, нийгмийн харилцаанд нөлөөлөх нь тархины сэрэл, саатлын процессийн онцлогоор тодорхойлогдох нейрофизиологийн үндэслэлтэй болохыг олон судлаачдын бүтээл нотолж байна.

Суралцагчдын темпераментийн онцлогт суурилсан сургалтын арга барилыг хэрэгжүүлснээр суралцах идэвх, оролцоо болон сургалтын амжилт уламжлалт сургалтын аргаас илүү сайжирна. Энэ чиглэлээр хийгдсэн судалгаануудыг тоймловол:

1. Темпераментэд тохируулсан сургалтын арга хэрэглэсэн суралцагчдын суралцах идэвх статистикийн хувьд мэдэгдэхүйц өссөн.
2. Экстраверт темпераменттэй суралцагчид нь бүлгийн болон харилцан хамааралтай аргаас илүү үр дүнтэй.
3. Интроверт темпераменттэй суралцагчид бие даасан болон эргэцүүлэн суралцах аргаас илүү өндөр үр дүн үзүүлсэн.

4. Темпераментэд суурилсан сургалтын арга барил нь суралцагчдын хичээлд хандах хандлагыг эерэгээр өөрчилсөн дүнгүүд тоймлогдлоо.

Судалгаануудын үр дүнгээс харахад темпераментэд нийцсэн сургалтын арга нь суралцах идэвх, оролцоо, хандлагыг дэмжих хандлага ажиглагдаж байна. Түүнчлэн суралцагчийн темперамент, сургалтын арга барилын уялдаа холбоог харгалзан үзсэн тохиолдолд сургалтын үр нөлөө сайжрах боломжтойг олон судлаачид онцолсон байна. Гэсэн хэдий ч темпераментэд суурилсан сургалтын арга барилын урт хугацааны үр нөлөө, тодорхой хичээлийн агуулгад тохируулан хэрэгжүүлэх арга зүйг нарийвчлан судалсан ажил хязгаарлагдмал хэвээр байна. Иймд цаашид энэхүү чиглэлээр илүү нарийвчилсан, системтэй судалгааг өргөжүүлэх шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

1. Nikolaos A Kostakopoulos, Themistoklis C Bellos, Stamatios Katsimperis, Lazaros Tzelves. (2024). Hippocrates of Kos (460-377 BC): The Founder and Pioneer of Clinical Medicine. Cureus. 2024 Oct 1;16(10): e70602. doi: [10.7759/cureus.70602](https://doi.org/10.7759/cureus.70602)
2. Willibald Ruch. (1992) Pavlov's types of nervous system, Eysenck's typology and the Hippocrates-Galen temperaments: An empirical examination of the asserted correspondence of three temperament typologies. Personality and Individual Differences. Volume 13, Issue 12, December, Pages 1259-1271; [https://doi.org/10.1016/0191-8869\(92\)90168-O](https://doi.org/10.1016/0191-8869(92)90168-O) Get rights and content
3. Barbara K. Keogh, Michael E. Pullis, Joel Cadwell. (1982). A Short Form Of The Teacher Temperament Questionnaire. Journal of Educational Measurement. Volume 19, Issue 4 pp. 323-329. December.
4. <https://doi.org/10.1111/j.1745-3984.1982.tb00138.x>
5. Lerner, J.V.; Lerner, R.M. (1983) Temperament and adaptation across life: Theoretical and empirical issues. In Life-Span Development and Behavior; Baltes, P.B., Brim, O.G., Eds.; Academic: New York, NY, USA
6. Martin, R.P.; Holbrook, J. (1985) Relationship of temperament characteristics to the academic achievement of first-grade children. J. Psychoeduc. Assess. 3, 131–140.
7. Zhang, Y. (2004). Temperament and academic achievement. Educational Research Review, 5(1), 12–25.
8. Brock, R., & Hundley, S. (2011). Student temperament and learning strategies. Journal of Educational Psychology, 103(2), 345–359.
9. Содномдаржаа, Д. (2019). Дээд боловсролын сургалтын арга зүйн шинэчлэл. Их сургуулийн судалгаа, 8(2), 30–38.